	1.3 Дүйцүүлэн нөхөн сэргээх, орчны тохижолт, цэцэрлэгжүүлэлт арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/	Дүйцүүлэн хамгаалал 1.100.000
	1.4 Ахуйн хог хаягдал	400.000 төг
	1.5 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	-
	1.6 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	1.800.000 төг
	1.7 Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	-
	1.8 Тухайн жилийн орчны хяналт,	580.000 төг

	шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	
	1.9 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	500.000 төг

### Тав. Мета мэдээлэл

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэнд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг байгаль орчны мэдээллийн санд оруулна.

- Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

№	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах хэсэг
5.1	Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл	
	Тосгон	
	Хог хаягдлын цэгийн байршил	
	Аюултай хог хаягдлын агуулахын байршил	
	Хаягдлын далан	
	Химийн бодисын агуулахын байршил	
	Орчны хяналт шинжилгээний дээж авах	
	Хяналтын цэгийн байршил	
	Тухайн жилд хуулах хөрс	
	Гадаад, дотоод овоолго	
	Техникийн нөхөн сэргээлтийн талбай	
	Биологийн нөхөн сэргээлтийн талбай	
	Гүний худгийн байршил	
	Дүйцүүлэн хамгаалал хийх газрын байршил	

**Зургаа. Тухайн жилийн арга хэмжээнээс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээний хяналтын хуудас**

Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэх багананд “тодорхойлсон”, “тодорхойлоогүй”, “хамааралгүй” гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.

Дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэргэжилтэн дүгнэлт гаргана.

Нөлөөллийн ангилал	А. Тооцсон эсэх	Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	В. Нөлөөллийн эрчмийг тодорхойлсон эсэх	Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	Дүгнэлт
6.1 Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл · Бахирдуулах · Эвдэх · Доройтуулах	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	
6.2 Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл · Бахирдуулах · Нөөцийг бууруулах	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	
6.3 Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл  · амьдрах орчинг хуваах · амьдрах орчинг доройтуулах · амьдрах орчинг хомсдуулах · нөөцийг бууруулах	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	
6.4 Агаарт үзүүлэх нөлөөлөл · Бахирдуулах · тоос	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	
6.5 Түүх соёлын дурсгалт эд зүйлс · Хамгаалах · Нүүлгэн шилжүүлэх	Тодорхойлоогүй	Тодорхойлоогүй	Тодорхойлоогүй	Тодорхойлоогүй	

**Долоо. Байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дүн шинжилгээний хяналт**

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “А” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх
- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “Б”, “В”, багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд “тийм”, “үгүй” хариулт өгнө.

- Доорх хүснэгтийн “Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг оновчтой тогтоосон эсэхэд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэргэжилтнүүд “хангалттай” “хангалтгүй” гэсэн дүгнэлт өгнө.

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А. Тоо	Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Г. Дүгнэлт
7.1.1 Нөлөөллөөс урьдчлан сэргийлэх зайлцуулах арга хэмжээ	5	тийм	тийм	
7.1.2 Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	6	тийм	тийм	
7.1.3 Нөхөн сэргээлтийн арга хэмжээ · техникийн/ га эзэлхүүн · биологийн /га	2	тийм	тийм	
7.1.4 Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	1	тийм	тийм	
7.1.5 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ	4	тийм	тийм	
7.1.6 Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	0	үгүй	үгүй	
7.1.7 Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	11	тийм	тийм	

#### **Найм. Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний хяналтын хуудас**

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийг “А, Б, В, Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

Хяналт шинжилгээний дээж	А. Дээж авах цэгийн тоо	Б. Дээж авах цэгийн байршил	В. Давтамж (удаа)	Г. Төсөв (төг)
1. Хөрс	2	Уурхайн ахилтанд өртөөгүй талбай	4	200,000

2. Ус	1	Худаг	4	50.000
3. Амътан	1	Тусгай зөвшөөрөлтэй талбайд	1	100.000
4. Ургамал	1	Уурхайн ахилтанд өртөөгүй талбай	1	100,000
5. Агаар	3	Уурхайн тээврийн зам дагуу	3	130,000

№ 000149263  
1204 дугаар талын байгуулалтад

ХҮЧИЙН ЭТГЭЭДИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГОРЧИЛГС

000149263

2005.10.15  
/Бүртгэсэн он, сар, өдөр /

0711001112  
/Хувийн хэргийн дуваар /

2011506  
/Регистрийн дугаар /

ДОЦ  
Хязгаарлагдмал хариуцлагатай компани  
/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Бүх гишүүдийн хурал  
/Үүсээн байгуулах баримт бичиг /

Тогтоол  
1  
1996.04.29  
/шиийдвэрийн нэр /  
/дугаар /  
/он, сар, өдөр /

4100  
7 код  
Барилга угсралт, засвар үйлчилгээ, барилгын сантехник, барилгын материал  
үйлдвэрлэл  
/Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

0141  
Туслах аж ахуй эрхлэк  
4610  
Гадаад, дотоод худалдаа эрхлэх  
4721  
Хүнс, бараа, барилгын материалын дэлгүүр нээх

/код /  
/Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй  
1  
622,787.3  
/хугацаа /  
/гишүүдийн тоо /  
/верийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Дорнод, Хэрлэн, 6-р баг, 1, Утас1: 99582650 Утас2: 99573030, Факс:  
/хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Гэрчилгээ дахин олгосон - 2018 он 8 сар 24 өдөр

Дорнод аймгийн Улсын  
бүртгэлийн хэлтэс  
/Бүртгэсэн байгууллагын нэр /

2018-08-24  
2018-08-24  
2018-08-24

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ОВООТ” ДО-002 ТООТ ТҮГЭЭМЭЛ  
ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙН 2024 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Балдан Оюур өвөлтөй Базаргуур-г Гүйцэтгэх зэхиралт-томилсны бүртгэв Дахин гэрчилгээ олгов	2018 08 24	Б.Болор-Эрдэнэ
2		2018 08 24	Б.Болор-Эрдэнэ





ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН АШИГЛАЛТЫН  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар ДО-002A

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь заалтыг үндэслэн

**ДОРНОД** аймгийн **ХЭРЛЭН** сумын **ОВООТ** нэртэй газарт орших **26.67** гектар талбай бүхий түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайд хуульд заасан нөхцөл шаардлагын дагуу түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахыг зөвшөөрч улсын бүртгэлийн **711001112** тоот гэрчилгээтэй “**ДОЦ**” **ХХК** -д энэхүү тусгай зөвшөөрлийг **2034.03.04** өдрийг дуустал 15 жилийн хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

ЗАСАГ ДАРГА

М.БАДАМСҮРЭН


2019 оны 03 сарын 04 өдөр

Чойбалсан хот

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН  
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН  
ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДУГЭР ХАВСРАЛТ

Тусгай  
зөвшөөрлийн  
дугаар ДО-002A

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Хөдөлгөөний код	Хөдөлгөөний тайлбар	Гарын үсэг, огноо, тамга
NM	-Аймгийн Засаг даргын 2019 оны А/102 дугаар захирамжаар ашиглалтын тусгай зөвшөөрөл олгов.	
AE	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөр төлөв. 2019-02-21	

ТУГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ  
ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН  
ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

Тусгай  
зөвшөөрлийн  
дугаар ДО-002A

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

№	Тусгай зөвшөөрөлд орох веерчлэлтийн үндэслэл	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицууд, огноо, гарын үсэг, тэмдэг		
				№	Үртраг	Өргөрөг
1		26.67		1	114-25-5.53	48-2-58.81
				2	114-25-25.61	48-2-58.81
				3	114-25-25.61	48-3-19.52
				4	114-25-5.53	48-3-19.52
2						
3						
4						
5						



МОНГОЛ УУДААСАН НАЦИОНАЛЬНЫЙ АУДИТ  
ЧИКИЙ ЧАЙНИЙ ИМПОРТЫН ЗОНЛОЛЫН  
ДҮГНӨЛТ

2019 - 07 - 04

Т/19-12-08

Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших ДО-002A тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Чойбалсан барилгын чулууны ордын зүүн хэсэг Овоот нэртэй ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэн тухай

"ДОЦ" ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн "Кеестон ресурс" ХХК боловсруулсан Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших Чойбалсан барилгын чулууны ордын зүүн хэсэг Овоот нэртэй ордыг ил аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэлд Монгол улсын уул уурхайн зөвлөх инженер Я.Дэрийлаамятав зөвлөж, Монгол Улсын зөвлөх инженер С.Алтанхуяг шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Төсөл боловсруулагч "Кеестон Ресурс" ХХК-ийн гүйцэтгэх захирал Л.Ганбат, төлөвлөлтийн инженер Э.Цэрэннадмид, эдийн засагч Э.Аззаяа, баяжуулалтын инженер Ч.Мягмарбаяр нар боловсруулав. Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Техник-эдийн засгийн үндэслэл нь Төслийн техник-эдийн засгийн үндэслэлийн танилцуулга, ордын геологийн судалгаа, ил уурхайн төлөвлөлт уурхайн ажлын горим, үйлдвэрийн хүчин чадал, уурхайн үйлдвэрлэлийн процесс, механикуулалд, барилгын чулуу бутлах технологи, уурхайн усан хангамж, цахилгаан хангамж, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, удирдлага зохион байгуулалт, төслийн ерөнхий төлөвлөлт, төслийн ерөнхий төлөвлөлт, эдийн засаг зэрэг 13 бүлэг, дүгнэлт, хавсралт материал, хавсралт тоосцоо бүхий 129 хуудас тайлбар бичиг, 23 хавсралт зургуудаас бүрдэж байна

2. Чойбалсан барилгын чулууны ордын зүүн хэсэг Овоот нэртэй ордын ДО-002A тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2018 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн хурлын ХХ-10-01 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГ-ын даргын 2018 оны 09 дугаар сарын 10-ний

өдрийн н/105 дүгээр тушаалаар дайрганы ордын нөөц нь бодитой В зэргээр 2236.87 мян.м<sup>3</sup> нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

3. Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо ашиглалтын үеийн хаягдал 1.72% (38.47 мян.м<sup>3</sup>), бохирдлыг 1.03%-аар (22.64 мян.м<sup>3</sup>) авч тооцсон ба ордыг 56 жилийн хугацаанд ашиглах бөгөөд энэ хугацаанд 203.93 мян.м<sup>3</sup> хөрс хуулж магадалсан В үйлдвэрлэлийн нөөцэд шилжүүлэн 2221.05 мян.м<sup>3</sup> буюу 5641.46 мян.тн дайрга олборлохоор төлөвлөсөн байна. Жилийн хүчин чадал 40.0 мян.м<sup>3</sup> бөгөөд хөрс хуулалтын итгэлцүүр 0.04 м<sup>3</sup>/тн.

4. Чойбалсан барилгын чулууны ордын зүүн хэсэг Овоот нэртэй ордыг ашиглахад эдийн засгийн үр ашигтай нөөцэд тулгуурлан ил уурхайн зардал бүтээгдэхүүн борлуулах үний 1 м<sup>3</sup> (-20+10 мм) ширхэглэлтэй дайргыг 22.0. (-10+5 мм) ширхэглэлтэй дайргыг 25.0. (-5+0 мм) ширхэглэлтэй дайргыг 8.0 мян.төг-өөр борлуулах эдийн засгийн тооцоог хийж ТЭЗҮ-ийг боловсруулсан байна.

5. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын нөөцийн тогтоц болон байршил, хөрсний зузаан, хөрсний чулуулгийн шинж чанар, зэргийг харгалзан үзэж авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ.

6. Уурхайн нээлт, ашиглалтын систем, олборлолтын хүчин чадлаас хамааруулж Atlas copco air rock D65 маркийн өрмийн машин 1ш, CATERPILLAR 330D1 маркийн экскаватор 1ш, HOWO маркийн автосамосвал 2ш, LQ968 маркийн утгуурт ачигч 1ш, зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар ТЭЗҮ-д тусгажээ.

7. Захиалагч байгууллагын санал болгосны дагуу Чойбалсан барилгын чулууны ордын зүүн хэсэг Овоот нэртэй ордын жилийн хүчин чадлыг дунджаар 40.0 мян.м<sup>3</sup> гэж тусгасан байна. Овоот нэртэй барилгын чулууны ордыг бүрэн олборлож дуусахад ашиглах хугацаа 56 жил болж байна. төслийг 56 жилийн хугацаатай олборлохоор ТЭЗҮ-ийг боловсруулсан байна.

8. Ордын уул-геологи, уул-техникийн нөхцөл, түүнчлэн ижил төстэй ордуудыг ашиглаж байгаа дэлхийн бусад улс орнуудын практик туршлага зэргийг үндэслэн Овоотын хэсгийн барилгын чулууны уурхайн ашиглалтад хамгийн тохиромжтой нь авто тээвэртэй ашиглалтын систем байна.

9. Ордын барилгын түүхий эдийн чанарын шинжилгээ, хорт хольц болон бутлан-ангилах туршилтыг "БАК"-ийн бетон дүүргэгч, барилгын физикийн лаборатори, цемийн физикийн судалгааны төвд тус тус туршилт судалгааны ажил хийгдсэн байна.

10.Дайрганы ширхгийн дундаж нягт нь дунджаар 2.43 г/см<sup>3</sup>, нимгэн үзүүрлэг хэсэг нь 4.97%, шаварлаг-тоосорхог хольц нь 0.37%, нягт 2.5 г/см<sup>3</sup>, ус шингээлт дунджаар 1.49%, чийглэг бүх дээжид 0.2% дунджаар 0.2% сувэрхэг чанар нь дунджаар 2.98%, ширхэг хоорондын зайд 52% байна. Урвалжих чадварын хувьд уусдаг цахиур ( $SiO_2$ )-ийн агууламж дунджаар 40.15 ммол/л . шүлтийн концентратын бууралт дунджаар 102% ммол/л байгаа нь хөнгөн болон хүнд бетоны эдлэхүүн хийхэд тохирч байна. Ордын чулууны элэгдэх чанар дунджаар 15.8% байна. Хүйтэн тэсвэрлэлт нь 2.06% байгаа нь шаардлага хангасан хүйтэн тэсвэрлэлт өндөртэй болохыг харуулж байна. Химийн найрлагын хувьд  $SiO_2$ -69.91%,  $Al_2O_3$ -12.61%,  $Fe_2O_3$ -3.29 %,  $CaO$ -3.23%,  $MgO$ -1.47%,  $K_2O$ -0.47%,  $Na_2O$ -

0.57%, SO<sub>3</sub>-0.15%, ШГХ-2.29% байна. Цацраг идэвхжилтийн судалгаагаар ордын чулуун дахь радиийн эквивалент нь дунджаар 178.25 Бк/кг байгаа нь барилгын материалд зөвшөөрөгдхөн хэмжээ 370 Бк/кг байхаас бага байгаа нь уг түүхий эдээр төрөл бүрийн бетон хийц үйлдвэрлэхэд бүрэн тохирох ба эрүүл ахуйн ямар нэг сөрөг нөлөөгүй болно.

11.Лабораторийн туршилтаар тогтоогдсон элс дайрганы гарцыг үндэслэн барилгын чулуу бутлах схемийг сонгосон ба 2 шатны бутлалт 1 шатны шигшилттэй байна. Бутлах цех нь ашиглалтын 56 жилийн хугацаанд 0-5 мм элс 91.29 мян.м<sup>3</sup>, 5-10 мм дайрга 1703.3 мян.м<sup>3</sup>, 10-20 мм дайрга 426.4 мян.м<sup>3</sup> бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

12.Олборлолтын явцад техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг MNS5915:2008, MNS5916:2008, MNS5918:2008, MNS5850:2008 зэрэг Монгол улсын стандарт зааварчилгааны дагуу гүйцэтгэж, уулын ажлын үр дунд үүссэн ухашийг нөхөн дүүргэж тэгшлэх, тухайн бүсийн уур амьсгалын нөхцөл байдалд тохирсон мод, бутлаг ургамлаар биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг хийж гүйцэтгэхээр зардлыг төсөлд тусгасан байна.

13.Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 56 жилийн хугацаанд 3477.8 сая төгрөг зарцуулахаар тооцсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах зардалд 350.7 сая төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн зардалд 1184.4 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 1567.4 сая төгрөг, төслийн хаалтын зардалд 375.3 сая төгрөг зарцуулахаар тусгажээ.

14.Уурхайн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 4180.9 сая төгрөг, төслийн нийт хугацаанд НӨАТ-ын дараах 47.42 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 35.95 тэрбум төгрөгийн зардал гарган, 14.51 тэрбум төгрөгийн цэвэр ашиг олж хөрөнгө оруулалтаа ашиглалтын 2.8 жилийн хугацаанд нөхөхөөр тооцжээ

15.Төслийн эхний 56 жилийн хугацаанд нийт 18.41 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд 10%-ийн хорогдуулалтын норм тооцсон өнөөгийн цэвэр үнэ цэнэ 9.5 тэрбум төгрөг, өгөөжийн дотоод норм 64.15% гарсан нь төсөл эдийн засгийн хувьд үр ашигтайгаар хэрэгжих боломжтой гэж үзжээ

16.Төсөл хэрэгжсэнээр улс, орон нутгийн төсөвт эхний 56 жилийн хугацаанд 11.62 тэрбум төгрөгийг татвар төлбөр хэлбэрээр төвлөрүүлэх ба 52 хүний ажлын байр шинээр бий болохоор төсөлд тусгажээ.

17.Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаль орчныг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байхыг ЭБМЗ-өөс даалгаж байна.

18.Техник, эдийн засгийн үндэслэл нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, уулын ажлын төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.

19. Энэхүү техник, эдийн засгийн үндэслэл нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хулээн авах журам"-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ

20. Засгийн газрын 379-р тогтоолоор батлагдсан "Тусгай зориулалтын авто зам замын байгууламж барих, ашиглах журам" – г тусгай зөвшөөрөл эзэмшигч компани нь мөрдөж ажиллахыг анхааруулж байна

21. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан болон усан хангамж, дэд бүтэц, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн "Кеестон ресурс" ХХК хариуцах, түүний үнэн бодит байдал, чанарт гаргасан дүгнэлтийг шинжээч Монгол улсын зөвлөх инженер С.Алтанхуяг хариуцах.

22. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд төдотгол хийлгэж, ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байх нь зүйтэй.

23. Захиалагч компани Техник-эдийн засгийн үндэслэлийг хулээн авах тухай Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын шийдвэр гарснаас хойш 5 хоногт багтаан Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвд холбогдох шаардлагад нийцүүлэн хулээлгэн өгөх үүрэгтэй. Энэ үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын дарга гаргасан шийдвэрээ тудгэлзүүлэх цуцлах эрхтэйг анхааруулах нь зүйтэй.

Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмал, газрын тосны газрын даргад Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлэлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн "Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших Чойбалсан барилгын чулууны ордын зүүн хэсэгт Овоот нэртэй ордын хэсгийг ил аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэл"-ийг хулээн авах шийдвэр гаргахыг уламжлахаар шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.МОНХТӨР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

*Хүснэгт*

Э.БОЛД-ЭРДЭНЭ

БАТЛАВ:

БОАЖЯ-НЫ ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

БОАЖЯ-НЫ ШИНЖЭЭЧ

Г.ЭНХМӨНХ

Б.БАТБАЯР

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН НУТАГТ ОРШИХ ЧОЙБАЛСАН  
БАРИЛГЫН ЧУЛУУНЫ ОРДЫН ЗҮҮН ХЭСЭГ ОВООТ НЭРТЭЙ  
ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

( Жилийн хүчин чадал 40.0 мян.м<sup>3</sup> барилгын чулуу )  
Тусгай зөвшөөрлийн талбайн дугаар MV-21000063 (ДО-002A)

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:

"ДОЦ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Б.БАЗАРГУР

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА:

"САУТ ВОЛИ" ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Э.ДАВААЖАВ



Байгаль орчны хяналт  
шинжилгээний хөтөлбөрт ажлын  
судалгааны тайлан

“ДОЦ” ХХК

# БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН “УРГАМЛЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН”

БОЛОВСРУУЛСАН:

“ДАЛАНГИЙН ХӨШӨӨТ” ХХК-ИЙН НАМГИЙН  
ЗАХИРАЛ *Д.Хөшөөт* /Э.ЭНХЖИН/



УЛААНБААТАР ХОТ  
2024 ОН

## БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Чойбалсан барилгын чулууны ордын зүүн хэсэг “Овоот” нэртэй ордыг “ДОЦ” ХХК-ийн эзэмшдэг ДО-002А ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 26,67 га талбай нь Дорнод аймгийн Хэрлэн сумын 6-р багийн нутаг дэвсгэрт оршдог.

“Овоот” нэртэй талбай нь Улаанбаатар хотоос зүүн тийш 650 км-т Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт Чойбалсан хотоос баруун тийш 7.5 км-т Хэрлэн голын хойд талд 803.0 тоот өндөрлөгтэй Овоот уулаас ЗХ 70 хэмээр 500 метр зайд М-50-133 хавтгайд байрлана.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (БОХШХ) нь уурхайн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон агуулахыг ашиглах явцад гарч болзошгүй эредэлийн үед байгаль орчинд бий болох бохирдол, доройтлыг тодорхойлох зорилготой заавал хэрэгжүүлэх баримт бичиг юм. Хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөх орчин тус бүрийг хянах гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх давтамж, шинжлэх арга, дээж авах, хадгалах, тээвэрлэх шинжлэхэд баримтлах стандарт шаардлага зэргийг багтаасан болно. БОХШХ-ийг хэрэгжүүлэхдээ энд заагдсан бохирдуулах эх үүсвэрүүдийг хянах Монгол Улсын хууль тогтоомж, стандартчилагдсан арга зүйн хязгааруудыг баримтлах шаардлагатай ба дээрх эрх зүйн актууд, стандартууд шинэчлэгдэвэл түүний шинэчилсэн хувилбарыг мөрдөж ажиллах ёстой. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж үр дүнг нь доорхи асуудлуудыг тодорхойлох, үнэлэхэд ашиглана. Үүнд:

- + Анх таамагласан сөрөг нөлөөлүүдийн хэмжээ, үр дагавараас бодит сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар хир зөрж байгааг,
- + Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт болон холбогдох эрх зүйн баримт бичиг, стандарт, дүрэм журамтай нийцэж байгаа эсэхийг,
- + Нөлөөлүүдийн эрчим, буурах эсвэл ихэсч байгааг,
- + Төслийн БОХТ-ний нийт үр ашгийг үнэлэх зэрэг орно.
- + Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх, батлагдсан арга зүйг баримтлан стандартчилагдсан багаж, хэрэгслээр дээж, шинжилгээ хийх болон өгөгдлийг боловсруулах ажлыг төслийн байгаль орчны асуудал хариуцсан ажилтанууд удирдан явуулна.

Мөн ордын олборлолт болон үйл ажиллагааг удирдан явуулж буй компани болон бусад гүйцэтгэгч, гэрээлэгч нар энэхүү БОХШХ-ийг үйл ажиллагаандaa баримтлах шаардлагатай.

Энэхүү БОХШХ-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсвийг тусгасан гүйцэтгэлийн менежментийн төлөвлөгөөг төслийн байгаль орчны асуудал хариуцсан зөвлөх болон ажилтнууд мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэн хяналт шилжилгээг өгөх хэрэгтэй. Гарсан дүгнэлтүүдийг байгаль орчны асуудал хариуцсан ажилтан нэгтгэн, зохих анализыг хийж холбогдох газруудад мэдэгдэж байвал зохино.

Түүнчлэн БОХШХ-ийг хэрэгжүүлэх чиглэлээр “Далангийн Хөшөөт” ХХК-тай 2024-05-16 өдрийн 24/006 тоот Байгаль орчны хяналт-шинжилгээний ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажиллаж байна.

## УРГАМЛЫН СУДАЛГАА

Дорнод аймгийн Хэрлэн сумын Чойбалсан барилгын чулууны ордын зүүн хэсэг “Овоот” нэртэй ордыг ил аргаар ашиглах судалгааны талбайн нь засаг захиргааны харьяаллаар Дорнод аймгийн Хэрлэн сумын нутаг ургамал – Ургамал газар зүйн мужлалыг тодруулбал энэ нутаг нь Евро-Азийн хээрийн их мужийн дагуур-Монголын дэд их муж, дагуур -Монголын хээрийн муж, Онон-Хянган орчмын дэд мужид хамаарах (Н.Өлзийхутаг, 1988) бөгөөд Нутгийн хойд болон өмнөд хэсгээр үетэн баялаг алаг өвс-зүр өвс тархах бөгөөд төв болон өмнөд хэсгээр алаг өвс-зүр өвс-үетэнт, алаг өвс тохиолдох онцлогтой.

Судалгааны талбай орчимд болон түүний нөлөөллийн бүсийн ургамалжилт, ургамлан нөмрөгийн төлөв байдлын иэмэлт тодотгол судалгааг 2024 оны 5 сард хийж гүйцэтгэсэн бөгөөд ургамлын төлөв байдлын судалгаанд 2015, 2023 оны судалгааны материалуудыг ашиглаж үр дүнг нэгтгэн боловсруулав.

#### **Судалгааны ажлын зорилго:**

Ургамлан нөмрөг, ургамлын бүтэц, бүрэлдэхүүнийн онцлог нь тэдгээрийг бүрдүүлж буй ургамлын төрөл, зүйл, тэдгээрийн элбэг ховор, ашиглагдах байдал, нөөц, тархац, экологи болон бүлгэмдлийн онцлог зэрэгтэй нягт холбоотой юм. Иймд эдгээрийг илрүүлж тогтоосноор тухайн газар нутгийн ургамлын бүрэлдэхүүн, ургамлан нөмрөгийг зөв зохистой ашиглаж хамгаалах боломжтой болох юм.

#### **Судалгааны обьект**

Чойбалсан барилгын чулууны ордын зүүн хэсэг “Овоот” нэртэй ордыг ил аргаар ашиглах “ДОЦ” ХХК-ийн эзэмшдэг ДО-002А ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 26.67 га талбай нь Дорнод аймгийн Хэрлэн сумын 6-р багийн нутаг дэвсгэрт Хэрлэн голын хойд талд 803.0 тоот өндөрлөгтэй Овоот уулаас ЗХ 70 хэмээр 500 метр зайд М-50-133 хавтгайд байрлана.


#### **Судалгааны арга зүйн:**

Судалгааны талбайн ойр орчимд тохиолдох дээд цоргот ургамлын жагсаалтыг гаргахдаа газар дээр нь бичиглэл ҳийж танъж тодорхойлоо ос гадна зарим үл танигдах ургамлуудыг фото зураг, хатаадас авч ургамлын төрөл зүйл тодорхойлох бичиг В. И. Грубов (1982), Н. Өлзийхутаг (1985), И. А. Губанов (1996) зэрэг ургамал ангилал зүйн бүтээлүүдийг ашиглан тодорхойлж ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг гаргасан.

Аргазүйн үндсэн агуулга нь судалгааны талбай дээр тогтмол хэмжилт судалгаа явуулах 50 м трансектүүдийг татан байрлуулж, түүний дагуу 1 м тутамд дартс төмөр хатган хэмжилт бичиглэл хийдэгт оршино. Энэ аргазүйн хүрээнд ургамал бүлгэмдлийн ерөнхий шинжийг тодорхойлогч зүйлийн бүрдэл, тусгагийн болон суурь бүрхэц, ургамлын тохиолдоц зэрэг мэдээллүүдийг цуглуулах ба ургамлын биомассыг трансектийн орчимд 1x1 м<sup>2</sup> талбайгаас 3 давталттайгаар ургамлын зүйлээр ялган авч хуурай жинг тодорхойлдог. Мэдээлэл цуглуулахдаа татсан трансектийн (50 м) дагуу 1 м тутамд дарлас төмөр хатган түүнийг орой хэсгээр ямар ургамал шүргэж байгааг ургамлын зүйл заан тэмдэглэх ба дарлас төмрийн үзүүрт тааралдах ногоон ургамлын дэгнүүл, суурь, эсвэл ургамалгүй халцгай газар, хайрга, чулуу зэргийг тогтоож, суурийн бүрхэцийг тодорхойлох ба үүнийг тусгайлан хүснэгтэнд тэмдэглэнэ. Ингэхдээ дарлас төмрийн үзүүрт тааралдсан ургамлын дэгнүүл эсвэл хагд өвс ямар ургамлынх болохыг ургамлын зүйлээр заан тэмдэглэнэ. Ургамлын тусгагийн бүрхэцийг трансектийн дагуу 10 м тутамд 1x1 м<sup>2</sup> хэмжээтэй Раменскийн тор тавин түүн доторх

бүх ургамлын зүйлийг тодорхойлж, ерөнхий болон ургамлын зүйлийн эзлэх бүрхэцийг хувиар тодорхойлон гаргалаа.

Дорнод аймгийн Хэрлэн сумын Чойбалсан барилгын чулууны ордын зүүн хэсэг “Овоот” нэртэй ордын ургамлан бүрхэвчийг тодруулан хээрийн судалгааны ажлыг Дорнод аймгийн Хэрлэн сумын нутгаар хээрийн бэлчээрт 4 удаа хийж гүйцэтгэв. Эхний судалгаараа ажиглалтын 2 цэгт, хоёр дахь судалгаагаар Дорнод аймгийн Хэрлэн сумын судалгааны талбайд 2 цэгт тус тус бичиглэл хийлээ.



### *Зураг №1. Шугам цэгийн арга*

**Зураглалын арга:** Судалгааны талбайн ургамалжилтын тархац, бүлгэмдлийн хил хязгаарыг тогтоохдоо “GPS” -ээр цэгийг тодорхойлж, ургамалжилтын өнгө газрын гадарга уул толгод баримжаалан “google” болон Монгол орны ургамалжилтын зураг, өндрийн тоон загвар, 1:100000 масштабтай байр зүйн зургуудыг давхцуулан түүнд тэмдэглэл хийж, ажиглалт хэмжилтийн цэг бүрээр зургийн тайллыг гарган багасгах масштабтай ургамалжилтын зургийг зохиов. Зураглалыг “ArcGIS 10.5” буюу газарзүйн мэдээллийн системийн программ хангамжийг ашигласан.

## Судалгааны үр дүн

## **Ургамлын зүйлийн бурдэл:**

Судалгааны талбайн нь цөлийн хээрийн бэлчээр бөгөөд 1 бүлгэмдэлд 9 овгийн 18 төрлийн нийт 22 зүйл ургамал бүртгэгдсэн. Энэхүү ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд

- |   |                                      |
|---|--------------------------------------|
|  сөөг              | 2,                                   |
|  олон наст өвс     | 13,                                  |
|  ганц ба хоёр наст | 7 зүйл ургамал тус тус тэмдэглэгдэв. |

**Судалгаа хийсэн талбайн ургамлын зүйлийн жагсаалт:**

**Хүснэгт №1. Судалгаа хийсэн талбайн ургамлын зүйлийн жагсаалт**

<b>№</b>	<b>Зүйлийн Латин нэр</b>	<b>Зүйлийн Монгол нэр</b>	<b>Амин хэлбэр</b>
<b>1.Roaceae-Биелэгтэн</b>			
1	<i>Achnatherum splendens</i>	цагаан Дэрс	Олон наст
2	<i>Cleistogenes songorica</i>	зүүнгарын Хазаар өвс	Олон наст
3	<i>Stipa gobica</i>	говийн Хялгана	Олон наст
4	<i>Chloris virgata</i>	саваан Булган сүүл	Нэг наст
5	<i>Eragrostis minor</i>	бага Хургалж	Нэг наст
6	<i>Setaria viridis</i>	ногоон хоног Будаа	Нэг наст
<b>2.Fabaceae-Цандуйтан</b>			
7	<i>Caragana stenophylla</i>	нарийн Навчит харгана	Сөөг
8	<i>Oxytropis aciphylla</i>	өргөст Ортууз	Сөөг
9	<i>Astragalus melilotoides</i>	хошоон Хунчир	Олон наст
<b>3.Asteraceae-Гол гэсэртэн</b>			
10	<i>Artemisia adamsii</i>	адамсын Шарилж	Олон наст
11	<i>Artemisia frigida</i>	агь Шарилж	Олон наст
12	<i>Artemisia scoparia</i>	ямаан Шарилж	Нэг наст
13	<i>Echinops Gmelinii</i>	гмелиний Тайжийн жинс	Олон наст
14	<i>Heteropappus hispidus</i>	арзгар Согсоолж	Олон наст
15	<i>Scorzoneroides divaricata</i>	дэрэвгэр Хависгана	Олон наст
<b>4.Chenopodiaceae- Луультан</b>			
16	<i>Kochia prostrata</i>	дэлхээ Тогторгоно	Олон наст
17	<i>Salsola arbuscula</i>	модлоглог Бударгана	Сөөг
18	<i>Bassia dasypylla</i>	үслиг Манан хамхаг	Нэг наст
19	<i>Chenopodium album</i>	цагаан Лууль	Нэг наст
20	<i>Corispermum mongolicum</i>	монгол Хамхуул	Нэг наст
21	<i>Halogeton glomeratus</i>	баг Хуш хамхаг	Нэг наст
22	<i>Salsola collina</i>	толгодын Бударгана	Нэг наст
<b>5.Rosaceae-Сарнайтан</b>			
23	<i>Potentilla bifurca</i>	имт Гичгэнэ	Олон наст
24	<i>Sibbaldianthe adpressa</i>	налчгар Хэрээ хошуу	Олон наст
<b>6.Brassicaceae-Тоонолжин цэцэгтэн</b>			
25	<i>Dontostemon senilis</i>	өтлүүн Багдай	Олон наст
26	<i>Lepidium densiflorum</i>	бөөн Цэцэгт цанггуу	Нэг наст
27	<i>Ptilotrichum canescens</i>	бууралдуу Янгиц	Олон наст
<b>7.Liliaceae-Сараанатан</b>			
28	<i>Allium polyrhizum</i>	Таана	Олон наст
29	<i>Asparagus gobicus</i>	говийн Хэрээн нүд	Олон наст
<b>8.Labiatae-Уруул цэцэгтэн</b>			
30	<i>Lagochilus ilicifolius</i>	ямаан Ангалзуур	Олон наст
31	<i>Panzeria lanata</i>	үсгүй Нохойн хэл	Олон наст
<b>9.Convolvulaceae-Сэдэрэгэний овог</b>			
32	<i>Convolvulus ammannii</i>	амманы Сэдэрэгэнэ	Олон наст
<b>10.Iridaceae-Цахилдагтан</b>			
33	<i>Iris bungei</i>	бунгийн Цахилдаг	Олон наст
<b>11.Zygophyllaceae-Хотирын овог</b>			
34	<i>Peganum nigellastrum</i>	өмхий Харлаг өвс	Олон наст



**“ДОЦ” ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨГӨЛБӨР**

*Dорнод аймгийн бүлэгчдийн ургамалжилсийн хэвшилийн:*


*Хүснэгт №2. Дорнод аймгийн бүлэгчдийн ургамалжилсийн хэвшилийн*

№	Бүлэгчдийн хэвшилийн	Хамрах нутаг	Хамрах тайбай, мянган	Ургам шт/га	Голгох зүйл
1	Хазаар өвс- хяланат	Хөлөнбуйр сумын хойт хэсэг	700 орчим	17	<i>Stipa decipiens</i> <i>Stipa klementzii</i> <i>Stipa baicalensis</i> , <i>Stipa grandis</i>
2	Агъ- хяланат	Хэрлэн сумын зүүн урдуур Баянтумэн Хэрлэн Баяндуун	-	8-10	<i>Potentilla acaulis</i> , <i>Aster biennis</i> , <i>Carex duriuscula</i> , <i>Cleistogenes squarrosa</i> , <i>Poa botryoides</i> , <i>Koeleria macrantha</i> , <i>Allium anisopodium</i> ,
3	Зүр өвст	Баянтумэн Гурванзагал Хэрлэн	-	-	<i>Stipa sibirica</i> , <i>Poa attenuata</i> , <i>Carex korjinskyi</i> , <i>Allium anisopodium</i> , <i>Hemerocallis minor</i> , <i>Iris dichotoma</i> , <i>Polygonum divaricatum</i> , <i>Saposhnikovia divaricata</i> , <i>Gypsophylla dahurica</i> , <i>Clematis hexapetala</i>
4	Алаг өвст хээр	Баянтумэн Хэрлэн Баяндуун	-	18	<i>Bupleurum scorzonerifolium</i> , <i>Thalectrum petaloideum</i> , <i>Arctogeron gramineum</i> , <i>Orostachys spinosa</i> , <i>Potentilla leucophloea</i>

## “ДОЦ” ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭНИЙ ХӨТӨЛБОР

*Дорнод аймгийн ургамлын тархай:*

СҮМЬИН НЭР	ТАЛБАЙ
Баян-Уул	457655.60
Баяндун	601597.40
Баянтумэн	827660.700
Булган	704342.2
Дашбалбар	860976.100
Хөлөнбүйр	375798.000
Сэргэлэн	407580.300
Цагаан-Овоо	636645.60
Гурванзагал	496058.4
Матад	2158135.5
Халхгол	2500894
Хэрлэн	21366.74
Чойбалсайн	959555.69
Нийт	11008266.23



### **Зураг №2. Дорнод аймийн үргамлын тархай**

**“ДОЦ” ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

*Дорнод аймагийн бэлчээрийн чадахи:*

*Хүснэгт №3. Дорнод аймагийн бэлчээрийн чадахи*

СҮМЫН НЭР	ТАЛБАЙ	1га бэлчээрийн майд ндэгдэх жилийн дундаж ургац/га	Тэжээлийн Нөөц /мян тн/	1га бэлчээрт байх мал /хонь толгой/	1 хонь толгойд ногдох бэлчээрийн .га	Бэлчээрийн чадавхи мян.хонь толгой мал
Баян-Уул	457655.60	3,2	146.4	0.6	1.6	276.3.
Баяндун	601597.40	3,2	1925.1	0.6	1.6	363.2
Баянтумэн	827660.700	3,2	264.8	0.6	1.5	156.1
Булган	704342.2	3,2	225.3	0.6	1.6	132.8
Дашбалбар	860976.100	3,2	2755.1	0.6	1.6	162.4
Хөлөнбүр	375798.000	3,2	120	0.56	1.6	226.4
Сэргэлэн	407580.300	3,2	130.4	0.6	1.6	246
Цагаан-Овоо	636645.60	3,2	203.7	0.6	1.6	384.3
Гурванзагал	496058.4	4	1850891.5	0.65	1.6	324718
Матад	2158135.5	2.1	4532084.6	0.4	1.6	795102.6
Халхтол	2500894	3.9	9753487.8	0.7	1.6	1711138
Хэрлэн	21366.74	3.3	29510.1	1.2	1.6	5177
Чойбалсан	959555.69	3.2	4877.7	0.3	1.6	856
<b>Нийт</b>	<b>11008266.23</b>	<b>3.271428571</b>	<b>16176622.5</b>	<b>0.616153846</b>	<b>1.6</b>	<b>2838662.8</b>



**“ДОН” ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
ХЯНАЛТ ШИНЖЛИГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

**Нэн ховор, ховор болон ашиглалтанд ортомтгийн ургамлын тархай:**


**ХЭРЛЭН СҮМ**

**Xүснэгт №4. Нэн ховор, ховор болон ашиглалтанд ортомтгийн ургамлын тархай**


Ургамлын статус	Ургамлын зүйл	Тэмдэглэгдсэн газар
Нэн ховор	-	-
Ховор ургамал	Урал чихэр өвс	Аймгийн төв орох замд, Атар бригадын орчим
Ашиглалтанд ортомтгийн ургамлын тархай	Марал навчил гичгэнэ	Сумын төв орчим
	Эмийн сөд	Сумын нутгаар
	Нагтар таван салаа	Сумын нутгаар

**“ДОЦ” ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

“ДОЦ” ХХК-ИЙН ДОРНОД АЙМГИЙН ХЭРЭН СУМЫН ЧОЙБАЛСАН БАРИЛГЫН ЧУЛУУНЫ ОРДЫН ЗУУН  
ХЭСЭГ “ОВООТ” НЭРТЭЙ ОРДЫН УРГАМАЛЖИЛТИЙН ЗУРАГ




Зураг №3. Судалгааны талбайн урзамал газарзүйн байришил



Зураг №4. Төслийн талбайн ургамалжилт

**Ургамлан бүлгэмдэл** Төслийн талбай ерөнхийдөө техникийн нөлөөгөөр талхлагдсан сөөг – алаг өвс-үетэнт бүлгэмдэл нь уулын чулуурхаг хажууд түлхүү тархан ургах бөгөөд уг бүлгэмлийг төлөөлүүлэн төслийн талбайд ургамлын бичиглэл хийв. **Ургамлын бичиглэл – 1** N 48° 3'13.52, E 114°25'9.67 д.т.д 1056 м ургамлын бичиглэлийг 1x1 м<sup>2</sup> талбайд хийв. Ургамлын тусгагын бүрхэц 50 – 60%, 1м<sup>2</sup> талбайд хавар ± 10 зүйл бүртгэгдсэн бөгөөд сөөг ургамлаас удвал навчит тавилгана (*Spiraea aquilegifolia*), үет ургамлаас хялгана *Stipa sibirica*, Нангиад Цагаан Суль (*Elymus chinensis*) Сибирь зүр өвс (*Filifolium sibiricum*), Саман Ерхөг (*Agropyron cristatum*), 15 – 20%, алаг өвснөөс Ацан Цахилдаг (*Iris dichotoma*), Ишгэн Шарилж (*Artemisia dracunculus*), Нуурга Хунчир (*Astragalus adsurgens*), Их Тавансалаа (*Plantago major*), Эмийн Сөд өвс (*Sanguisorba officinalis*), Нүцгэн Намуу (*Papaver nudicaule*), хөх яргуй (*Pulsatilla turczaninovii*, *P.flavescens*), зэрэг ургамлууд тохиолдож байна. Ургамлын ерөнхий бүрхэц 40-45 %, хайрга чулуун бүрхэц 20-30 %, ургамлын дундаж өндөр 15-20 см, талхлагдлын зураг багаас дунд зэрэг байна.



Зураг №5. Ургамлын бичиглэл, ургацын дээж авч буй байдал

**Ургамлан бүлгэмдэл** Төслийн судалгааны талбайн баруун хойд захад нарийн жалга дагаж хиаг – алаг өвс – улалж тархан ургах бөгөөд уг бүлгэмлийг төлөөлүүлэн төслийн талбайд ургамлын бичиглэл хийв.

**Ургамлын бичиглэл – 2** N 48°3'1.45, E 114°25'8.01, д.т.д. 971 м-т орших 1x1 м<sup>2</sup> талбайд хавар 5 сард ± 8 зүйл бүртгэгдсэн бөгөөд зун ± 12 зүйл тохиолддог байна. Энд ширэг улалж (*Carex duriuscula*), Нангиад Цагаан Суль (*Elymus chinensis*) 25%-иар зонхицж, алаг өвснөөс галуун гичгэнэ (*Potentilla anserine*), Их Тавансалаа (*Plantago major*), Эмийн Сөд өвс (*Sanguisorba officinalis*), Нугын Шимтэглэй (*Geranium pratense*) зэрэг ургамлууд тохиолдох бол нугын дээд хэсгээх нарийн ам хөндийг дагаж сөөг Жижигнавчit Харгана (*Caragana microphylla*) 3%, Соргүй Согоовор (*Bromus inermis*), Томцэцэгт Дурваа, Даагансүүл (*Koeleria macrantha*) 10%, Хонин Ботууль (*Festuca ovina*), Сибирь Ботууль (*Festuca sibirica*), Сибирь Биелэг (*Poa sibirica*) зэрэг үетэн 3-5%-ийн, Маралнавчit Шарилж (*Artemisia tanacetifolia*), Дэлбээрхүү Буржгар (*Thalictrum petaloideum*), Эгэл Өрөмтүүл (*Galium verum*), Одой Далантүрүү (*Stellera chamaejasme*), Эмийн Сөд өвс (*Sanguisorba officinalis*), Турчаниновын Яргуй (*Pulsatilla turczaninovii*), Ацан Цахилдаг (*Iris dichotoma*) Одой Сараана (*Lilium pumilum*) зэрэг алаг өвс 1-5% -ийн бүрхэцтэй харин хотгор газраар Шивүүрт Сарнай (*Rosa acicularis*), Маралнавчit Гичгэнэ (*Potentilla tanacetifolia*), Эгэл Өрөмтүүл (*Galium verum*) зэрэг зүйлүүд бөөгнөрч ургадаг. Бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц хавар 20% байна. Ургамлын дундаж өндөр 5 см. Ургамлан нөмрөг төлөв байдлын хувьд хүн технологийн нөлөөгөөр өөрчлөлтөнд их орсон байна. Энд ургамлын биомасс 50 см<sup>2</sup> талбайд 10 гр байна.



Зураг №6. Ургамлын бичиглэл, ургацын дээж авч буй байдал

**Ургамлан бүлгэмдэл** Судалгааны талбайд Үетэн - Алаг өвс – Зүр өвст нугажуу хээр нь жалгийн хажуу, нарийн ам, хөндийг дагаж тохиолдох бөгөөд уг бүлгэмлийг төлөөлүүлэн төслийн талбайд ургамлын бичиглэл хийв.

**Ургамлын бичиглэл – 3** N 48°3'1.93, E 114°25'21.36 д.т.д. 1020 м-т орших 1x1 m<sup>2</sup> талбайд хийв, 1m<sup>2</sup> талбайд ± 20 – 25 зүйл ургамал тохиолдох бөгөөд Сибирь Цагаансуль (*Elymus sibiricum*) 35%-иар зонхилж, Пумпеллийн Согоовор (*Bromus pumpelliana*), Хонин Ботууль (*Festuca ovina*), Сибирь Ботууль (*Festuca sibirica*), Сибирь Биелэг (*Poa sibirica*) зэрэг үетэн 3-10%-ийн, Маралнавчт Шарилж (*Artemisia tanacetifolia*), Дэрвээн Буржгар (*Thalictrum simplex*), Нууын Шимтэглэй (*Geranium pratense*), Алтанзул, Шар хумхаал (*Hemerocallis minor*), Эгэл Өрөмтүүл (*Galium verum*), Хулганын Гиш (*Vicia cracca*), Хос Гиш (*Vicia unijuga*), Одой Далантүрүү (*Stellera chamajasme*), Эмийн Бамбай (*Valeriana officianalis*), Эмийн Сөд өвс (*Sanguisorba officianalis*), Шар Яргуй (*Pulsatilla flavescens*), Турчаниновын Яргуй (*Pulsatilla turczaninovii*), Одой Сараана (*Lilium pumilum*) зэрэг алаг өвс 1-5%-ийн бүрхэцтэй харин хотгор газраар Шивүүрт Сарнай (*Rosa acicularis*), Маралнавчт Гичгэнэ (*Potentilla tanacetifolia*), Эгэл Өрөмтүүл (*Galium verum*) зэрэг зүйлүүд бөөгнөрч ургадаг бол үетэн - Алаг өвс – Зүр өвст нугажуу хээрийн дээд хэсгээр сөөг – үетэн – алаг өвст бүлгэмдэл буюу удвал навчт тавилгана (*Spiraea aquilegifolia*) зонхилсон уулын хажуу бэл залган ургана. Бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц 80-90% байна. Ургамлын дундаж өндөр 10 см, ургамлын биомасс хавар 50 cm<sup>2</sup> талбайд 46 гр байна. Ургамлан нөмрөг төлөв байдлын хувьд ерөнхийдөө өөрчлөлтөнд бага орсон хэдий бэлчээрийн малын хөлийн нөлөөлөлд бага зэрэг орсон байна.



Зураг №7. Ургамлын бичиглэл, ургацын дээж авч буй байдал

**Ургамлан бүлгэмдэл** Төслийн судалгааны талбайн зүүн урд захад зам дагуу хиаг – алаг өвс – улалж тархан ургах бөгөөд уг бүлгэмлийг төлөөлүүлэн төслийн талбайд ургамлын бичиглэл хийв.

**Ургамлын бичиглэл – 4** N 48°3'13.47, E 114°25'9.59, д.т.д. 971 м-т орших 1x1 m<sup>2</sup> талбайд намар 9 сард ± 6 зүйл бүртгэгдсэн бөгөөд зун ± 11 зүйл тохиолддог байна. Энд ширэг улалж (*Carex duriuscula*), Томцэцэгт Дурваа, Даагансүүл (*Koeleria macrantha*) 10%, Хонин Ботууль (*Festuca ovina*), Сибирь Ботууль (*Festuca sibirica*), Сибирь Биелэг (*Poa sibirica*) зэрэг үетэн 3-5%- ийн, Маралнавчт Шарилж (*Artemisia tanacetifolia*), Дэлбээрхүү Буржгар (*Thalictrum petaloïdum*), Эгэл Өрөмтүүл (*Galium verum*), Одой Далантүрүү (*Stellera chamajasme*), Эмийн Сөд өвс (*Sanguisorba officinalis*), Турчаниновын Яргуй (*Pulsatilla turczaninovii*), Ацан Цахилдаг (*Iris dichotoma*) Одой Сараана (*Lilium pumilum*) зэрэг алаг өвс 1-5% -ийн бүрхэцтэй харин хотгор газраар Шивүүрт Сарнай (*Rosa acicularis*), Маралнавчт Гичгэнэ (*Potentilla tanacetifolia*), Эгэл Өрөмтүүл (*Galium verum*) зэрэг зүйлүүд бөөгнөрч ургадаг. Бүлгэмдлийн өрөнхий тусгагийн бүрхэц хавар 50% байна. Ургамлын дундаж өндөр 5 см. Ургамлан нөмрөг төлөв байдлын хувьд хүн технологийн нөлөөгөөр өөрчлөлтөнд их орсон байна. Энд ургамлын биомасс 50 см<sup>2</sup> талбайд 10 гр байна.



Зураг №8. Ургамлын бичиглэл, ургацын дээж авч буй байдал

“ДОЦ” ХХК

# БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН “АМЬТНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН”

БОЛОВСРУУЛСАН:

“ДАЛАНГИЙН ХӨШӨӨТ” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ


/Э.ЭНХЖИН/

УЛААНБААТАР ХОТ  
2024 ОН

### АМЬТНЫ АЙМАГ

#### Төсөл хэрэгжих бүс нутгийн амьтны аймгийн ерөнхий тойм.


“ДОЦ” ХХК-ийн Дорнод аймгийн Хэрлэн сумын Чойбалсан барилгын чулууны ордын зүүн хэсэг “Овоот” нэртэй ордыг ил аргаар ашиглах судалгааны талбайн нь байрлах бөгөөд Монгол орны амьтны газарзүйн мужлалаар Дагуурын Монголын хээрийн тойрогт (Банников, 1954) хамаардаг. Эндхийн зэрлэг хөхтний зүйлийн олонхи, ялангуяа жижиг хөхтний тархац, байршлын тойм аль нэг хэмжээгээр мэдэгдэж байгаа боловч нарийвчилсан тодорхой судалгаа бага юм. Төслийн нутаг бол Төв Азийн угуул зүйл цагаан зээрийн нопуляцийн байршил, тоо толгой, үржлийн үндсэн голомт болдог (Дуламцэрэн, 2001) онцлогтой. Шувуудын хувьд Монголын болон Азийн, дэлхийн улаан номд бүртгэгдсэн, олон улсын конвенц / CITES/ -ийн хавсралтад бүртгэгдсэн тоо толгой нь ховордож байгаа цэн тогоруу, хар тогоруу, цагаан тогоруу, алаг тогоруу, нүүдлийн үедээ дайрч өнгөрдөг өөр хаана ч бүртгэгдээгүй **дорнын өрөвтас, халzan оровтас, ухаа шумбуур, хээрийн хавмгаалэс, ясагар хөхөө** зэрэг зүйлүүд дэлхийд ховордож байгаа **цэн тогоруу, харихараа тогоруу өвөгт тогоруунууд** өндөглөөд зусдаг. Монгол улсад 128 зүйл хөхтөн амьтан бүртгэгдсэн. Тус нутагт Хөхтөн амьтан дотор хээрийн хөхтний булгэмдэлд багтах Дагуур огдой, Цагаан зээр элбэг тархсан, Дагуур зурам, Орог зусаг, Дорнодын шишүүхэй, Хэргэлзэй оготно, Улийн цагаан оготно хэвийн тархсан, Монгол тарвага, Дагуур зурам, Монгол чичүүл зэрэг амьтад цөөн тоогоор тархжээ



Зураг №9. Монгол орны амьтны аймгийн газар зүйн мужслал

